



2022 он 03 сар 19 өдөр

Дугаар 22/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн хурал  
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Улаанбаатар хот Корпоройт зочид буудал, Конвешн Центр-т хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.

6. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Applikeйшн (Ard App) болон цаас хосолсон хэлбэрээр авахаар зохион байгуулалтыг хангахыг хурлын даргад даалгасугай.
9. Хурлын даргаар “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн ТУЗ-ийн дарга Г.Цогбадрахыг томилсугай.
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Хурал зохион байгуулах комиссын дарга:
    - “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандааг
  - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
    - “Ард Секьюритиз ҮЦК” ХХК-ийн ахлах шинжээч Ч.Даваасамбуу
    - “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн ТУЗ-ийн нарийн бичиг Ч.Хандсүрэн
11. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - Тооллогын комиссын дарга:
    - “Блүмсбюри Секьюритис ҮЦК” ХХК-ийн Г.Алтансүх
  - Тооллогын комиссын гишүүд:
    - “Хулан Адвокейт ХНХ”-ийн Р.Тогтохбаатар
    - “Блүмсбюри Секьюритис ҮЦК” ХХК-ийн Б.Ариунзул
12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
13. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Хандаад даалгасугай.

ДАРГА



Г.ЦОГБАДРАХ